

11

ӨВӨР МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Б.Хөгжилт

ӨМӨЗО нь БНХАУ-ын умар хязгаарт байршиж, талбай 1.183 сая км², Хятадад 3-т байрлан, 2006 оны эцсээр хүн амын тоо 23.92 сая, үүнд монгол үндэстэн 4.24 сая, бүх хүн амын 17.7 хувийг эзлэн, нийт 38 үндэстэн ястантай.

Нэг. Эдийн засгийн ерөнхий тоо хэмжээ

2000 онд ӨМ-ын ДНБ 153.912 тэрбум юань байснаа 2006 онд 479 тэрбум юань болж, жилийн дундаж өсөлт 17.1%-д хүрч, үүнд 2002-2005 онуудын жилийн өсөлтийн хурдаар Хятадад түрүүлж, хамгийн хурдацтай үе 2005 онд 23.8%-д хүрсэн байна. 2006 онд ӨМ-ын ДНБ Хятадын 2% орчимыг эзэлж, мужын зэрэглэлийн засаг захиргааны жагсаалтанд 2000 онд 24-т байснаа 2006 онд 17-т байрлаж, хүн амд ноогдох ДНБ 2006 онд 20047 юаньд хүрч, 3 жилд 10000 юаниар өссөн байна.

Тухайн жилүүдэд ӨМ-ын санхүүгийн орлого нэлээд хурдтай нэмэгдэж, 2006 он гэхэд 71.29 тэрбум юаньд, жилийн дундаж өсөлт 28.1%-д, үүнд орон нутгийн төсвийн орлого 34.334 тэрбум юаньд хүрч, Хятадад 2000 онд 23-т байрлаж байснаа 2006 онд 20-т байрлажээ.

Хоёр. Эдийн засгийн бүтэц

2000 оноос хойш ӨМ нь аж үйлдвэржилтийн ахицаа түргэтгэж, аж үйлдвэржилт нь эхний үе шатаас дунд үе шатанд шилжиж, гурван аж үйлсийн(салбарын)нэмэгдэл өртөгийн харьцал 2000 оны 22.8:37.9:39.3 байснаас 2006 оны 13.4:48.6:38 болж, хөдөө аж ахуйн эзлэх хувь мэдэгдэхүйц буурч, аж үйлдвэр нь эдийн засгийн өсөлтийн гол болох хүчин зүйлийн нөлөөлөл чангарч, үйлчилгээний салбарын өөрчлөлт арай багатай хэвээрээ байна. Үүнд хөдөө аж ахуйн нэмэгдэл өртөг 2006 онд 64.17 тэрбум юань, жилийн өсөлт 6.6%-д хүрч, “өсдүгээр таван” жилийн

өсөлтөөс 0.2%-иар нэмэгдэж, мал аж ахуйн хувийн жин 45.4% хүртэл нэмэгдэж, үнээний сүү, хонины мах, ноолуурын гаралтаар Хятадад тэргүүлж, ам будааны гаралтаар 12-т байрлажээ (хүснэгт 1).

Хүснэгт 1

Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүний хувийн жингийн байдал

Салбар	2000	2001	2002	2003	2004	2005
Том Тариалан	56.8	55.3	56.6	50.6	48.5	48.3
Үүнд: Газар тариалан	50.2	48.7	51.8	39.6	39.2	39.2
Ой шугуй	4.4	4.7	4.9	8.2	6.1	5.4
Мал аж ахуй	37.6	38.9	37.6	40.3	44.6	45.4
Загас	1	1.1	0.9	0.9	0.8	0.9
Нийт	100	100	100	100	100	100

Материалын эх үүсвэр: (Өвөрмоголын эдийн засгийн статистик 2007)

Аж үйлдвэрд зургаан тулгуур том салбар буюу цахилгаан эрчим хүч, төмөрлөг боловсруулах, хими, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах, механикийн, дээд шинэ технологи зэрэг салбарын хөгжил өргөжил хүчтэй байж, 2006 онд аж үйлдвэрийн нэмэгдэл өртөг 197.8 тэрбум юань, жилийн өсөлт 21.5%-д хүрч, үүнд 2003-2005 онуудад томхон аж үйлдвэрийн нэмэгдэл өртөгийн өсөлтөөр гурван жил дараалан Хятадад тэргүүлжээ (хүснэгт 2).

Хүснэгт 2.

2005 оны тулгуур том салбарын байдал нэгж: тэрбум юань %

салбар	Нэмэгдэл өртөг	өмнө таван жилийн дундаж өсөлтийн хурд
Эрчим хүч	44.39	36.3
Төмөрлөг боловсруулах	31.08	41.4
Хими	5.94	29.1
Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах	25.66	33.1
Механик	2.66	34.2
Нийт	109.74	

Материалын эх үүсвэр: «Өвөрмоголын эдийн засгийн статистик 2007»

2005 онд сүү, ноолуурын цамцны үйлдвэрлэлээр Хятадад тэргүүлж, нүүрс, цэвэр хужир, цахилгааны гаралтаар тус тус 2, 7, 9-т байрлажээ.

Дээрх хөгжил өргөжлийн зэрэгцээ эдийн засгийн бүтцэд доорх асуудлууд оршиж байгааг үгүйсгэхгүй. Нэгдүгээрт, салбар дахь гинж хэлхээс урт биш, гүнзгий боловсруулалт муу, бүтээгдэхүүний нэмэгдэл өртөг доор. Хоёрдугаарт, эдийн засгийн өсөлтийн хэлбэр маяг эрчимжээгүй, нөөц баялгийг ерөнхийлэн ашигласан түвшин өндөр биш. Гуравдугаарт, үйлчилгээний салбарын хөгжил харьцангуй удаан.

Дөрөвдүгэрт, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн арга маяг хоцронгуй, эрчимжих, бүсжих, төрөлжих орчин үеийн шаардлагаас зөрүү ихтэй байсаар байна.

Гурав. Бүс нутгийн хөгжил

2000 оноос хойш ӨМ нь тэнцвэртэй бус хөгжлийн жам ёсыг мөрдөж, нөөц баялаг төвлөрсөн болон давуу талтай бүс нутгийг урьдчилан хөгжүүлэх бодлого хэрэгжүүлснээс Хөх-хот, Бугат, Ордос гурвалжин эдийн засгийн өндөрлөг буй болсон хэдий ч зүүн барууны зөрүү улам бүр ихэссэн байна. Өөрөөр хэлбэл 2000-2006 онуудад бүх аймаг хотын ДНБ болон санхүүгийн орлогын жилийн өсөлт 10% давсны дотор Хөх-хот, Бугат, Ордос, Үхай, Алаша зэрэг 5 аймаг хотын ДНБ-ий өсөлт 20%-г, Хөх-хот, Бугат, Ордос, Үхай 4 хотын орон нутгийн санхүүгийн орлогын өсөлт 30%-г давж, 2005 онд Хөх-хот, Бугат, Ордос, Шилингол, Үхай, Алаша зэрэг 6 аймаг хотын хүн амд ноогдох ДНБ нь Орны дундаж түвшинээс, Хөх-хот, Бугат, Ордос, Үхай, Алаша зэрэг 5 аймаг хотын хүн амд ноогдох орон нутгийн санхүүгийн орлого Орны дундаж түвшинээс давж, бусад аймаг хот хоорондох зөрүүг улам бүр ихэссэн байна (хүснэгт 3). 2006 онд Хинган аймгаас бусад орон нутгийн санхүүгийн орлогын өсөлт бүр 10%-г давж, эдгээрээс хамгийн хурдтай өсөж байгаа нь Ордос хот 58.1%-д хүрсэн байна.

Хүснэгт 3.

2005 он дахь бүх аймаг хотын ДНБ ба ОНСО-н байдал (нэгж: тэрбум юань, юань, %)

Аймаг хот	ДНБ	Оронд эзлэх хувь	Хүн амд ноогдох ДНБ	ОНСО	Оронд эзлэх	Хүн амд ноогдох ОНСО
Хөх-хот	74.37	18.1	29049	4.93	17.7	1926
Бугат-хот	84.87	20.6	35086	6.12	21.9	2530
Хөлөнбуйр-хот	32.41	7.9	11971	2.22	8.0	821
Хинган аймаг	12.04	2.9	7513	0.63	2.3	396
Тунглио-хот	32.93	8.0	10616	1.86	6.7	599
Улаанхад-хот	34.77	8.4	7894	2.0	7.2	454
Шилингол аймаг	16.92	4.1	17093	1.35	4.8	1346
Улаанцав аймаг	23.02	5.6	10592	1.3	4.7	597
Ордос-хот	59.48	14.5	40169	4.61	16.5	3114
Баяннуур-хот	21.7	5.3	12560	1.36	4.9	784
Үхай-хот	12.55	3.0	27272	0.93	3.4	2024
Алаша аймаг	6.46	1.6	30587	0.51	1.8	2432
Нийт дүн	411.52	100	16331	27.83	100	1404.2

Материалын эх үүсвэр: «Өвөрмоголын эдийн засгийн статистик 2007»

Дээрх байдлаас харвал, Хөх-хот, Бугат, Ордос нь Орны эдийн засгийн өсөлтийн “сүргийн толгой” болж, 2005 онд ДНБ-ээр Орны 53.2%-г эзлэж, 2000 оныхоос 13.9%-иар өсөн, санхүүгийн орлогоор 56.6%-г эзлэж, 2000

оныхоос 9.1%-иар өсөн, хүн амд ноогдох ДНБ 33623 юань, Орны дундаж түвшинээс 17292 юань өндөр байна.

Үүний зэрэгцээ хошууны шатны эдийн засгийн хүчин чадал эрс нэмэгдэж, (Хятадын Шианы шатны эдийн засгийн өрсөлдөх чадварын үнэлгээ) илтгэлийг үндэслэвэл, ӨМ-ын цогцолбор өрсөлдөх чадвар нь 2000 онд 22-т байснаас 2005 онд 13-т байрлаж, мужийн зэрэглэлийн засаг захиргаанд хамгийн их өсөлттэй бүс нутаг болсон байна. Мөн зүүн бүсийн өсөлт удаан байгаагийн шалтгаан нь Нэгт, өөрийн хөрөнгийн хуримтлал багатай, өөрийн хөрөнгө оруулалт дутмаг. Хоёрт, бүтцийн талаар аж үйлдвэр хоцронгуй, хотжилтийн түвшин доор. Гуравт, дэд бүтэцийн хөгжил муутай. Дөрөвт, нөөц баялаг, бодлогийн хязгаарлагдмал байдал зэргүүд болно.

Үүнээс гадна хот хөдөөгийн байдлаас үзвэл, 2006 онд хотын хүн амын эзлэх хувь 48.6% болж, ДНБ-ий 60-аас дээш хувийг хотын хүн ам үйлдвэрлэж, хот хөдөөгийн орлогийн зөрүү ихэссэн байна. Өөрөөр хэлвэл 2006 онд хот болон хөдөөгийн хүн амын орлого тус тусдаа 9137 юань, 2989 юань байж, үүнийг 2000 оны 3091 юаньтай харьцуулахад зөрүү нь 3000 гаруй юаниар өссөн байна.

Дөрөв. Орлогын байдал

2000 оноос хойш ӨМ-ын хүн амын орлогын түвшин мэдэгдэхүйц дээшилж, хотын хүн амын орлогын жилийн өсөлт 10.5%, Хятад дахь байр суурь нь өмнө нь 23-т байснаа 14-т хүрч, хөдөөгийн хүн амын орлогын жилийн өсөлт 5.1%, харин өмнө нь 16-т байснаа 17-т болж буурсан байна.

Үүнд хотын оршин суугчдын орлогод доорх өөрчлөлт гарсан байна. 1) цалингийн болон эд хөрөнгийн орлогын эзлэх хувь өсөж, 2) шилжүүлэлтийн болон бизнесийн орлогын эзлэх хувь буурж, 3) салбар хоорондох орлогын зөрүү ихэссэн байна.

Шилжүүлэлтийн орлого өндөр бус байгаа нь нийгмийн халамж даатгалын систем төгөлдөр бус байгаатай холбоотой. Өөрөөр хэлбэл Нэгт, аж ахуйн нэгжийн заавал тушаах нийгмийн даатгалын шимтгэл хангалтгүй. Хоёрт, нийгмийн даатгалын хамрах цар хүрээ бага. Гуравт, хувийн аж ахуй эрхлэгч, хувиараа ажиллагчдын даатгалд оролцох норм хэмжээ доор. Дөрөвт, бүх шатны нийгмийн даатгалын систем бүрэн утгаараа хэрэгжиж эхлээгүй.

Бизнесийн орлогын хувийн жин буурсны гол шалтгаан бол Нэгт, их хэмжээний хотын бүтээн байгуулалтаас хэсэг бизнесийн орон зайг эзлэж. Хоёрт, хэсэг хувийн бизнес эрхлэгчид томорч компани пүүс руу шилжсэн. Гуравт, үйлдвэр худалдааны засаг захиргааны байгууллагын хянан байцаах чадвар дээшилсэн. Дөрөвт, зах зээлийн өрсөлдөөн чангарсан зэрэгтэй холбоотой.

Салбаруудын хоорондох орлогын зөрүү ихэссэн байдлаас харвал, 2005 оны хамгийн их орлоготой эрчим хүч, усан хангамжийн салбарын ажилтны дундаж цалингийн орлого нь хамгийн бага орлоготой хөдөөгийн

аж ахуйн салбараас 3.57 дахин. Мэдээлэл, компьютер, шинжлэх ухаан технологи ба геологи хайгуулын салбар зэрэг, мэдлэг нягтарсан салбар нь өндөр орлоготой салбар болж, технологийн шаардлага доор, хөдөлмөр нягтарсан салбар нь доор орлоготой салбар болж байна /хүснэгт 4/.

Хүснэгт 4.

2005 оны салбаруудын ажилтны дундаж цалин Нэгж: юань/жил, %

Д/д	Салбар	Дундаж цалин	Орны дундаж цалинд хэлбэ
	Орны дундаж цалин	15985	100
1	Эрчим хүч, усны хангамж	30661	191.8
2	Мэдээлэл, компьютерын үйлчилгээ	24579	153.8
3	Мөнгөн гүйлгээ	20812	130.2
4	Соёл урлаг, спорт	19359	121.1
5	Зам тээвэр, шуудан	19124	119.6
6	Шинжлэх ухаан, технологи, геологи хайгуул	19109	119.5
7	Олон нийтийн байгууллага	18440	115.4
8	Боловсрол	18049	112.9
9	Эрүүл мэнд, нийгмийн халамж даатгал	17633	110.3
10	Түрээслэх, бизнес үйлчилгээ	16763	104.9
11	Хүдэр олборлох	16184	101.2
12	Үйлдэх зохион бүтээх	14497	90.7
13	Зочид буудал, хоолны газар	14215	88.9
14	Орон сууц, гэр хөрөнгө	13397	83.8
15	Усжилт, байгаль орчин	13062	81.7
16	Бөөний болон жижгэлсэн худалдаа	11596	72.5
17	Барилга	11574	72.4
18	Оршин суугчдын үйлчилгээ	10239	64.1
19	Хөдөө аж ахуй	8588	81.7

Материалын эх үүсвэр: «Өвөрмоглын эдийн засгийн статистик 2007»

Дүгнэлт

Хятадын төв засгаас “баруун бүсийг ихээр хөгжүүлэх” бодлого хэрэгжүүлснээс хойш, Өвөрмонгол нь өөрийн нөөц баялаг, орон байрны давуутайгаа уялдуулан, зах зээл болон засаг захиргааны хоёр гарын үйлдлийг зүй зохистой бадруулж, эдийн засгийн өсөлт нь урьдын хэв

тогтуун шатнаас өндөр хурдтай шатанд орж, ялангуяа 2002-2005 онуудад ДНБ-ий өсөлтийн хурдаар Хятадад тэргүүлж, эдийн засгийн макро үзүүлэлт, байр суурь, орон бүсийн хөгжил аль алинд нь их өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- (1) ДНБ-ы жилийн дундаж өсөлт 2000-2006 онд 17.1%, 2002-2005 онд Хятадад тэргүүлж, ДНБ-ий байр суурь 2000 онд 24-т байсан бол 2006 оны 17-т оржээ.
- (2) Хүн амын орлогын түвшин мэдэгдэхүйц дээшилж, мөн жилүүдэд хотын хүн амын орлогын жилийн өсөлт 10.5%. Хятад дахь байр суурь өмнө нь 23-т байснаа 14-т хүрч, хөдөөгийн хүн амын орлогын жилийн өсөлт 5.1%, харин өмнө нь 16-т байснаа 17-т болж буурсан байна.
- (3) Эдийн засгийн бүтцийн хувьд гурван аж үйлсийн (салбарын) нэмэгдэл өртгийн харьцал 2000 оны 22.8:37.9:39.3 байснаас 2006 оны 13.4:48.6:38 болж, хөдөө аж ахуйн эзлэх хувь мэдэгдэхүйц буурч, аж үйлдвэр нь эдийн засгийн өсөлт дэх гол болох хүчин зүйлийн нөлөөлөл чангарч, аж үйлдвэржилт эхний шат үеэс дунд шат үед шилжин, эдийн засагт оруулах хувь нэмэр их бүхий зургаан том салбар буй болж, үйлчилгээний салбарын өөрчлөлт арай багатай хэвээрээ байна.
- (4) Бүс нутгийн хөгжлийн хувьд, урьдын суурь нөхцөл болон тэнцвэртэй бус бодлого хэрэгжүүлснээс зүүн барууны зөрүү ихэсч, Хөх-хот, Бугат, Ордос нь Орны эдийн засгийн хөгжлийн “сүргийн толгой” болсон хэдий ч зүүн бүсийн аймаг хотуудын хөгжил удаан байна.

Ашигласан материал:

1. Д.Дагвадорж. маркетингийн судалгаа. УБ 2007.
2. Төв Азийн шилжилтийн эдийн засагтай орнуудад тулгарч буй асуудлууд. УБ.2007.
3. А.Шагдарсүрэн.Хөрөнгө оруулалтын эдийн засгийн асуудал. УБ2007.
4. Ц.Баатар. Глобалчлалын эриний монгол улсын эдийн засгийн гадаад харилцаа. УБ2007.
5. www.nmg.gov.cn